СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БАРУУН-УРТ СУМ
2025 он

# СҮХБААТАР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 1: Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | |
| 1.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2-т заасан Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана. | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | - | Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | Улсын байцаагчийн зөвлөмж 1 удаа хүргүүлсэн. | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Сумдын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээнд сар бүр хяналт хийж шалгуур хангаагүй эмчийн хасагдал 122,158.4 мян төгрөг, оношилгоо шинжилгээний нэхэмжлэлийг health.gov.mn програмаас сар бүр татаж регистрийн дугаарын давхардлыг шүүж 150 хүний 2235.0 мян.төг давхардал, ЭМДҮЗ-ийн 03-р тогтоолын дагуу сарын нэхэмжлэх дүн хэтрүүлсэн 140 хүний 2254.0 мян төг хасалт хийж Мэдээлэл технологийн хэлтэст мэдэгдэж илүү нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх тохиргоог програмд хийж өгөх саналыг хэлсэн. Мөнххаан сум 2024 онд ЭМГ-аас хувиарласан стрептококийн хурдавчилсан сорил оношилгоог 313 хүний 1878.0 мян төгрөгийг 6000 төгрөгөөр нэхэмжилсэнийг програмд хасалт хийж сум бүрт мэдэгдэж тайлбарласан. Дээрх тулгасан жагсаалтыг хэлтсийн даргаар хянуулж баталгаажуулж байна. | 90 |
| 2. | Арга хэмжээ 1.1.2 Эрүүл мэндийн даатгалын 2024 оны статистик | - | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | Эрүүл мэндийн даатгалын | Статистик мэдээллийг олон нийтэд | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас статистик мэдээллийн эмхэтгэл ирээгүй байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | | | 2023 оны статистик мэдээллийн эмхэтгэл гараагүй. | түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна | ЭМДЕГазрын цахимд хуудсанд тавигдсан статистик мэдээллийг хэлтсийн цахимаар хаягт 36 удаа түгээсэн. | |
| 3. | Арга хэмжээ 1.1.3<br>“Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо<br>- Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ-ийн 2024 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажилласан байна. | Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам шинэчлэн батлах” 4 дүгээр тогтоолуудыг гэрээт эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн, 2 удаа сургалт, зөвлөгөө өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 85 |
| 4. | Арга хэмжээ 1.1.4<br>“ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах” тухай ЭМДҮЗ-ийн шинэчлэн батлагдсан тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | - | -Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо<br>-Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна | Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам шинэчлэн батлах” 03 дугаар тогтоолыг гэрээт эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн 2 удаа сургалт өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Анхан шатны 14 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж төсвийн сарын хуваарийг гаргуулан худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн.<br>Өрх, сумын 14 эрүүл мэндийн байгууллагын 01-04 дүгээр сарын 15949 хүний 1,492.7 сая төгрөгийн нэхэмжлэлийг хүлээн авч хянан 14316 хүний 1,261.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон. Хасагдал 1633 хүний 231.2 сая төгрөг. | 90 |
| 5. | Арга хэмжээ 1.1.5<br>Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | - | Санхүүжүүлсэн мөнгөн дүн Хамрагдсан даатгуулагчийн тоо | ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2024 онд 1423 иргэнд 243,6 | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, | ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолын дагуу эрт илрүүлэг үзлэг, оношилгоо шинжилгээнд 540 хүний 86.8 сая төгрөгний нэхэмжлэлийг хүлээн авч хянан 537 хүний 86.2 сая төгрөгийг олгохоор тооцсон. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон. | санхүүжилтийг баталгаажуулсан байна.. | | |
| 6. | Арга хэмжээ 1.1.6<br>ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | - | -Хийсэн дүн шинжилгээний тоо, -Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | Сумдын ЭМТ-н алсын дуудлага, оношилгоо шинжилгээ тусламж үйлчилгээнд дүн шинжилгээ хийж сумын эрүүл мэндийн төвүүдэд улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | Гэрээт 42 эрүүл мэндийн байгууллагатай 2024 оны гүйцэтгэлээр тооцоо нийлж баталгаажуулан, санхүүгийн тайлангийн хамт санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.<br>Сумдын ЭМТ-н оношилгоо шинжилгээ тусламж үйлчилгээнд дүн шинжилгээ хийж хасагдлын мэдээг сумын эрүүл мэндийн төвүүдэд сар бүр хүргүүлж, улсын байцаагчийн 17 зөвлөмж, улсын байцаагчийн 2 албан шаардлага хүргүүлсэн. Нэхэмжлэлийн хяналт хийх явцад анхан шатны маягт, ЭМДҮЗ-ийн 12-р тогтоолын шалгуур зөрүүтэй байгааг БТГ-т санал хүргүүлсэн. | 85 |
| 7. | Арга хэмжээ 1.1.7<br>“ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо<br>-Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо | ЭМДҮЗ-ийн 11-р тогтоолын дагуу 2024 онд 23 гэрээ бүхий эмийн сангийн 52448 хүний 1,710,627.6 сая төгрөгний нэхэмжлэлийг хүлээн авч 52353 хүний 1,697.8 сая төгрөгний нэхэмжлэлийг хянаж эрүүл мэндийн | Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна. | Эрүүл мэндийн сайдын А/521 тоот тушаал, ЭМДҮЗ-ийн 11-р тогтоолын дагуу 23 эмийн сантай гэрээ байгуулж 20027 хүний 623,356.1 сая төгрөгний нэхэмжлэлийг хүлээн авч хянан 20027 хүний 623,351.9 сая төгрөгний санхүүжилтийг олгохоор тооцсон. | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагуу дад хүргүүлж ажилласан | | | |
| 1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 8. | Арга хэмжээ 1.2.1<br>*Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.1.3, БГТ-1.4.3*<br>Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | -Хүргүүлсэн саналын тоо | Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад 6 удаа санал хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичигт холбогдох санал ЭМДҮЗ-н 10 тогтоол, 4 журамд санал боловсруулж хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2 удаа, ЭМДЕГазрын даргын А/139 тоот тушаал, ЭМСайдын А/611 дүгээр тушаал, ЭМДЕГ-ын даргын А/160 тоот тушаалд Улсын байцаагчийн ажиллах дүрэм, эрүүл мэндийн даатгалын хамрагдалт нэмэгдүүлэх тогтоолын төсөлд 1 удаа санал хүргүүлсэн. | 90 |
| 9. | Арга хэмжээ 1.2.2<br>Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана. | - | Зөрчлийн хэргийн тоо | 2024 оны аймгийн Прокурорын байгууллагатай хамтран гэмт хэрэгт холбогдсон 58 хүний лавлагааг гарган өгч ажилласан. | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | Прокурорын байгууллагаас зөвлөгөө авч сургалтад 1 удаа хамрагдсан. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн эрүүл мэндийн даатгалын сангаас гарсан хохирлыг 15 иргэний нэхэмжлэлийг гарган прокурортой хамтран ажилласан. | 85 |
| **2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | |
| 2.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т заасан "Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| | Арга хэмжээ 2.1.1<br>*ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050"-МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2,* | - | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 37 | 2025 онд 40 хувиас дээш хамруулна. | Баруун-Урт сумын 1-9 дүгээр багийн дарга нарт сургалт мэдээлэл өгсөн. Нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээнд 1 удаа оролцож эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчилж, мэдээллээр ханган, даатгалд хамруулах | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10. | *МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7. БГТ 2.1.1*<br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | | | | | үйл ажиллагааг аймгийн төвийн томоохон худалдааны төв, үйлчилгээний байгууллага гэрээт эмнэлэгүүдтэй хамтарч нийт 1650 иргэнд мэдээлэл өгсөн.<br>Төлөвлөгөө 1784 хүн<br>Биелэлт- 1181 хүн 173.4 сая төг -66 хувь | 90 |
| | | - | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 68 | 2024 онд 70 хувиас дээш хамруулна. | Төлөвлөгөө 213 хүн<br>Биелэлт- 787 хүн 99,6 сая төг 370 хувь | |
| | | - | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2024 оны хамрагдалтын хувь 30 | 2024 онд 40 хувиас дээш хамруулна. | Нээлттэй хаалганы өдөрлөг бусад арга хэмжээнд оролцсон иргэдээс 320 иргэний төлөлтийг газар дээр нь шалгаж, 225 иргэн даатгалаа ебаримтаар төлсөн.<br>Төлөвлөгөө 1225 хүн<br>Биелэлт- 908 хүн 91.0 сая төг 74 хувь | |
| | | - | Байгууллага, аж ахуйн нэгжийн хувь | 2024 оны хамрагдалтын хувь 80 | 2024 онд 80 хувиас дээш хамруулна. | Төлөвлөгөө 2950 хүн<br>Биелэлт-3032 хүн 2,594.9 сая төг 102 хувь | |
| | | - | Гадаадын иргэн, харьяалалгүй иргэн | 100 хувь | 100 хувь | Төлөвлөгөө 10 хүн<br>Биелэлт- 19 хүн 1.5 сая төг 103 хувь | |
| 11. | Арга хэмжээ 2.1.2<br>Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ. | - | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо | 2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээг гарган жилд 3 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган 4 удаа хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээ үзүүлсэн нэхэмжлэл, албан тоотыг дараа сарын 01-ээс 05-ны дотор цахимаар /sua-invoice@emd.gov.mn/, хаягаар хүлээн авч (health.gov.mn) програмтай тулган 01-04 дүгээр сард 308 нэхэмжлэлийг хүлээн авсан. Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг сар бүр хугацаанд нь гарган хүргүүлж байна. | 100 |

<table>
<tr><th>1</th><th>2</th><th>3</th><th>4</th><th>5</th><th>6</th><th>7</th><th>8</th></tr>
<tr>
<td>12.</td>
<td>Арга хэмжээ 2.1.3<br>ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,<br>Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.</td>
<td>-</td>
<td>Төвлөрүүлсэн мөнгөн дүн</td>
<td>2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 85 хувьтай.</td>
<td>ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 90 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.</td>
<td>2025 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай.
<table>
<tr><th>№</th><th colspan="2">Ажил олгогч даатгуулагчын төлөх шимтгэл /1-4 сарын байдлаар/</th><th colspan="2">Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, суралцагсдын төлөх шимтгэл /1-4 сарын байдлаар/</th></tr>
<tr><th></th><th>Төлөвлөгөө /хүний тоо/</th><th>Орлого /хүний тоо/</th><th>Төлөвлөгөө /хүний тоо/</th><th>Орлого /хүний тоо/</th></tr>
<tr><td>1</td><td>2950</td><td>3832</td><td>3231</td><td>3544</td></tr>
</table>
Зардлын гүйцэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллагатай сар бүр тулган гүйцэтгэлийг явуулж байна.
<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Эрүүл мэндийн байгууллага</th><th rowspan="2">Тусламж үйлчилгээ</th><th colspan="2">Нэхэмжилсэн дүн</th><th colspan="2">Хасагдал</th><th colspan="2">Олгохоор тооцсон дүн</th></tr>
<tr><th>Хүний тоо</th><th>Мөнгөн дүн</th><th>Хүний тоо</th><th>Мөнгөн дүн</th><th>Хүний тоо</th><th>Мөнгөн дүн</th></tr>
<tr><td rowspan="3">1</td><td rowspan="3">Аймгийн нэгдсэн эмнэлэг</td><td>Үндсэн тусламж үйлчилгээ</td><td>48486</td><td>6,158,268,805.00</td><td>866</td><td>349,467,946.00</td><td>47620</td><td>5,808,800,859.00</td></tr>
<tr><td>Төр хариуцах</td><td>404</td><td>14,595,307.00</td><td>0</td><td>-</td><td>404</td><td>14,595,307.00</td></tr>
<tr><td>Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг</td><td>777</td><td>127,440,000.00</td><td>3</td><td>886,000.00</td><td>773</td><td>126,554,000.00</td></tr>
<tr><td>2</td><td>Уламжлалтын анагаах ухааны нэгдсэн эмнэлэг</td><td>Үндсэн тусламж үйлчилгээ</td><td>1250</td><td>239,591,616.00</td><td>21</td><td>15,641,176.00</td><td>1229</td><td>223,950,440.00</td></tr>
<tr><td>3</td><td>Хувийн эмнэлэг</td><td>Эмийн эмчилгээ</td><td>639</td><td>360,436,054.00</td><td>13</td><td>7,815,892.00</td><td>626</td><td>352,620,162.00</td></tr>
<tr><td rowspan="3">4</td><td rowspan="3">Сумын эрүүл мэндийн төв</td><td>Үндсэн тусламж үйлчилгээ</td><td>5748</td><td>254,360,000.00</td><td>768</td><td>35,039,000.00</td><td>4980</td><td>219,321,000.00</td></tr>
<tr><td>Шинэ тусламж үйлчилгээ</td><td>5903</td><td>1,135,757,705.00</td><td>759</td><td>193,872,603.00</td><td>5144</td><td>941,885,102.00</td></tr>
<tr><td>Анхан шатны санхүүжилт /нэг иргэн/</td><td>41667</td><td>4,046,938,109.00</td><td></td><td></td><td>41667</td><td>4,046,938,109.00</td></tr>
<tr><td rowspan="2">5</td><td rowspan="2">Өрхийн эрүүл мэндийн төв</td><td>Үндсэн тусламж үйлчилгээ</td><td>4298</td><td>102,679,000.00</td><td>106</td><td>2,379,000.00</td><td>4192</td><td>100,300,000.00</td></tr>
<tr><td>Анхан шатны санхүүжилт /нэг иргэн/</td><td>24328</td><td>535,893,328.00</td><td></td><td></td><td>24328</td><td>535,893,328.00</td></tr>
<tr><td>6</td><td>Эмийн сан</td><td>Эм</td><td>15080</td><td>468,043,896.00</td><td>0</td><td>4,222.00</td><td>15080</td><td>468,039,674.00</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td></td><td>148580</td><td>13,444,003,820.00</td><td>2536</td><td>605,105,839.00</td><td>146043</td><td>12,838,897,981.00</td></tr>
</table>
</td>
<td>90</td>
</tr>
<tr><td colspan="8">2.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т заасан “Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална” зорилтын хүрээнд:</td></tr>
<tr>
<td>13.</td>
<td>Арга хэмжээ 2.2.1<br>Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2.2.1, БГТ-2.2.1<br>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.</td>
<td>-</td>
<td>-Өглөг, авлагын тоо хэмжээ<br>-Тайлан</td>
<td>2024 онд 3,1 тэрбум төгрөгийн өглөгтэй тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.</td>
<td>Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна.</td>
<td>2024 онд гэрээт 42 эрүүл мэндийн байгууллагад 1,025,909.5 мян төгрөгний өглөгтэй гарсныг ЭМДЕГ-аас 1-р улиралд барагдуулсан.</td>
<td>100</td>
</tr>
<tr><td colspan="8">3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна</td></tr>
</table>

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 14. | *Арга хэмжээ 3.1.1*<br>*Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.1.2, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1*<br>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ дүгнүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 2024 онд гэрээт 42 ЭМБ-ын гэрээг дүгнэсэн | Гэрээт ЭМБ-уудын гэрээг хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. | Гэрээт 42 эрүүл мэндийн байгууллагын 2024 оны гэрээний биелэлтийг дүгнэж 35 байгууллага хангалттай үнэлгээ авч, Баяндэлгэр, Мөнххаан, Наран, Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумын эрүүл мэнд төв, Хатавч тун эмийн санд зөвлөмж хүргүүлсэн. | 90 |
| | | - | Гэрээний хэрэгжилтийн хувь | 2024 онд гэрээний хэрэгжилт 90 | Гэрээний хэрэгжилтийн хувь 90 хувиас доошгүй байна. | Гэрээний хэрэгжилтийн хувь 90 | |
| 15. | *Арга хэмжээ 3.1.2*<br>2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Шинэчлэн байгуулсан гэрээний тоо | Гэрээтэй 23 эмийн сантай гэрээ байгуулж, дүгнэх ажлыг хагас бүтэн жилээр зохион байгуулж ажилласан. Шинээр 1 эмийн сан гэрээ байгуулахад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-үүдтай гэрээ байгуулагдсан байна. | 2024 онд 23 эмийн сангийн гэрээг дүгнэж 2025 онд 23 эмийн сантай ЭМДЕГ-ийн дарга гэрээ байгуулан ажиллаж байна. Шинээр хүсэлт ирүүлсэн эмийн сан байхгүй байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16. | *Арга хэмжээ 3.1.3*<br>Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан | Лавлагаа шатлалын гэрээт- 5, СЭМТ-12, ӨЭМТөв-2, эмийн сан-23 гэрээт байгууллагад 3 удаа мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан. | Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна. | ЭМДЕГ-ийн даргын А/30 тоот тушаал “Нэхэмжлэлийг хянах журам”-ийг гэрээт лавлагаа шатлалын- 5, СЭМТ-12, ӨЭМТөв-2 байгууллагад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 90 |
| 3.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т заасан “Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 17. | Арга хэмжээ 3.2.1<br>БГТ-3.2.1<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | - | Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн | Нийт 42 ЭМБ-д 33,5 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийг хянаж 31,5 тэрбум төгрөгний гүйцэтгэл олгохоор тооцсон | Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хугацаанд нь журмын дагуу хэрэгжүүлсэн байна | Гэрээт 42 эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлд хяналт хийж 2233 хүний 521,045.2 мян төгрөгний хасагдлын мэдээг хүргүүлж ажилласан. | 90 |

| № | Эрүүл мэндийн байгууллага | Тусламж үйлчилгээ | Эмчийн хасагдал | | Байцаагчын хасагдал | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Аймгийн нэгдсэн эмнэлэг | Үндсэн тусламж үйлчилгээ | 55 | 45,989,117.00 | 155 | 16,234,076.00 |
| 2 | Уламжлалтын анагаах ухааны нэгдсэн эмнэлэг | Үндсэн тусламж үйлчилгээ | 5 | 3,093,240.00 | 0 | - |
| 3 | Хувийн эмнэлэг | Эмийн эмчилгээ | 4 | 2,179,121.00 | 0 | - |
| 4 | Сумын эрүүл мэндийн төв | Үндсэн тусламж үйлчилгээ | 297 | 21,460,000.00 | 396 | 3,151,000.00 |
| | | Шинэ тусламж үйлчилгээ | 589 | 160,485,775.00 | 0 | - |
| 5 | Өрхийн эрүүл мэндийн төв | Үндсэн тусламж үйлчилгээ | 42 | 961,000.00 | 38 | 520,000.00 |
| 6 | Эмийн сан | Эм | 0 | - | 0 | - |
| | **Нийт** | | **992** | **234,168,253.00** | **589** | **19,905,076.00** |

<table>
<tr><th>1</th><th>2</th><th>3</th><th>4</th><th>5</th><th>6</th><th>7</th><th>8</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>Бусад аймаг, дүүргийн гэрээт эрүүл мэндийн байгууллагын түүврийг цахимаар хүлээн авч хугацаанд нь хянасан.
<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Эрүүл мэндийн байгууллага</th><th rowspan="2">Хянасан ЭМБ-ийн тоо</th><th colspan="2">Хянасан түүврийн нэхэмжилсэн дүн</th><th colspan="2">Түүврийн шалгуур хангаагүй хасагдал</th></tr>
<tr><th>Хүний тоо</th><th>Мөнгөн дүн</th><th>Хүний тоо</th><th>Мөнгөн дүн</th></tr>
<tr><td>1</td><td>Ч.Тамираа</td><td>51</td><td>1522</td><td>7,500,000,000.00</td><td>208</td><td>193,955,142.00</td></tr>
<tr><td>2</td><td>Г.Мөнгөнцэцэг</td><td>59</td><td>2804</td><td>6,363,445,640.00</td><td>120</td><td>98,695,853.00</td></tr>
<tr><td>3</td><td>С.Нарантуяа</td><td>2</td><td>3403</td><td>467,316,801.00</td><td>328</td><td>38,436,517.00</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td>112</td><td>7729</td><td>14,330,762,441.00</td><td>656</td><td>331,087,512.00</td></tr>
</table></td><td></td></tr>
<tr><td>18.</td><td>Арга хэмжээ 3.2.2<br>БГТ-3.2.3<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.</td><td>-</td><td>Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо</td><td>2024 онд 42 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн</td><td>Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.</td><td>Гэрээт эрүүл мэндийн 42 байгууллагад ЭМДҮЗ-ийн 2024 оны 05, 06, 14-р тогтоол, 2025 оны 03, 04 дүгээр шинэчлэгдсэн тогтоолоор цахим болон танхимын сургалтыг давхардсан тоогоор 225 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт мэдээллийг өгсөн.</td><td>90</td></tr>
<tr><td>19.</td><td>Арга хэмжээ 3.2.3<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.</td><td>-</td><td>Хүргүүлсэн зөвлөмжийн тоо<br>Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь</td><td>2024 онд нийт улсын байцаагчийн 22 зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг хянаж ажилласан.</td><td>Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг тухай бүр холбогдох нэгжид хүргүүлсэн байна.</td><td>Лавлагаа шатлал-5, анхан шатны 14 гэрээт эрүүл мэндийн байгууллагатай төсвийн хуваарь хийлгүүлж батлагдсан хуваарийн дагуу сар бүр гүйцэтгэлийн нэхэмжлэлийг, health.gov.mn програмтай тулган давхардал, шалгуур хангаагүй, эмч, байцаагчийн хасагдлын мэдээг сар бүр хүргүүлж, зөвлөмж 17 хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаж байна.</td><td>90</td></tr>
<tr><td>20.</td><td>Арга хэмжээ 3.2.4<br>Байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 3.2.3, БГТ-3.2.2<br>Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, санал үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.</td><td>-</td><td>Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо<br>-Хяналт шалгалтын тайлан</td><td>2024 онд гэрээт 3 ЭМБ-д газар дээрх хяналт шалгалтыг зохион байгуулсан.</td><td>Газар дээрх хяналт, шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид тухай бүр хүргүүлсэн байна.</td><td>Сүхбаатар сумын ЭМТ, Манду фарм гэрээт эмийн сангийн 2025 оны 01,02 дугаар сарын эмийн нэхэмжлэлд газар дээрх хяналт шалгалт хийж улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж биелэлтийг тооцож ажилласан.</td><td>90</td></tr>
</table>

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Халзан сумын эрүүл мэндийн төвд ЭМДЕГазрын Худалдан авалт гэрээлэлтийн газраас ирсэн 07/232 тоот дотоод бичгийн дагуу шүд амны хөндий тусламж үйлчилгээг шинээр гэрээлэх хүсэлтийн дагуу газар дээрх хяналт хийж, зөвлөн туслах үйл ажиллагааг цахимаар хийж гүйцэтгэлээ. | |
| **4.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | |
| 4.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан “Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 21. | Арга хэмжээ 4.1.1<br>*ЗГҮАХ-2.1.9, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.3*<br>Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | | -Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.<br>-Тайлан | Аймаг орон нутгийн чанартай сургалтад хамрагдаж, Ерөнхий газраас зохион байгуулсан нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт бүрэн хамрагдсан. | Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 3 албан хаагч эхний хагас жилээр тайлагнасан. 2025 оны эхний хагас жилийн бүтээмжийн урамшууллыг 3 албан хаагч авсан. Орон нутгийн нэмэгдэл 10 хувийн 1-р улиралын урамшууллын санхүүжилтийг төрийн сангаас шилжүүлээд байна. ЭМДЕГ-аас шинээр 3 үйлдэлт принтер 1ш, 16 gb рамтай процессор 2ш, цэвэрлэгээний бараа материал ирүүлснийг хүлээн авсан. Актлах, сольсон хуучин тоног төхөөрөмжийн материалыг тооцооны нягтланд хүргүүлсэн. АЗДТГ, ЭМГ-аас зохион байгуулсан 6 удаагын сургалтад 3 албан хаагч хамрагдсан.<br>Хэлтсийн 2 өрөөнд гэрээт үйлчлэгчээр өдөр тутам цэвэрлэгээг тогтмол хийлгэж, сард 1 удаа их цэвэрлэгээг 3 албан хаагч хийж байна. | 100 |
| 22. | Арга хэмжээ 4.1.2<br>Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг | - | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Нээлттэй хаалганы өдөрлөг 3 удаа, цахим хуудсаар мэдээлэл авсан иргэн | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | ЭМДЕГ-ийн пэйж хуудсанд орсон мэдээ мэдээллийг хэлтсийн пэйж хуудас хаягаар аймгийн их дагагчтай 21 цахим хаягуудад тухай бүр шэйрлэж, иргэдэд түгээж байна. Байгууллагын пэйж хуудсанд ажлын өдөр 1-ээс доошгүй пост, баннер рийлийг бэлтгэн оруулж хэвшсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулна. | | | 10003, сургалтад хамрагдсан иргэд 1652 | | Хэлтсийн пэйж хуудас 358 хүнээр нэмэгдэж, хандалт 2950, шэйр 330 удаа хийсэн. Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор ЭМДЕГ-аас ирүүлсэн сургалт сурталчилгааны тараах материал, гарын авлагыг гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, мэдээллийн самбарт байршуулж, аймгийн төвийн томоохон худалдааны төв, үйлчилгээний байгууллагаар гэрээт эрүүл мэндийн байгууллагатай хамтарч 1850 иргэнд мэдээлэл өгсөн. Үүнээс 579 иргэний төлөлтийг газар дээр нь шалгаж, 186 иргэн төлөлтөө ебаримтаар төлсөн. | 90 |
| 23. | Арга хэмжээ 4.1.3<br>Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | 1452024 онд 3398 иргэн, даатгуулагчдад мэдээ, мэдээллийг хүргэсэн. | 2024 онд 150-аас доошгүй иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг хүргэсэн байна. | Эрүүл мэндийн газар, гэрээт эрүүл мэндийн албан хаагчдад хэлэлцүүлэг, сургалтыг 42 байгууллагад 2 удаа цахим болон танхимаар өгсөн. Баруун-Урт сумын засаг даргын тамгын газраас "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгуулахад Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тусламж үйлчилгээ авах талаар албан байгууллагын албан хаагч, малчин, оюутан, хувиараа бизнес эрхлэгч нарт эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчилж, мэдээллээр хангаж оролцсон.<br>Мөн байгууллагын пэйж хуудсаар дамжуулж иргэдийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ сар бүр тогтмол төлүүлэх нөлөөллийн ажлыг хийж байна.<br>Баруун-Урт сумын 1-9 дүгээр багийн багийн дарга нарт мэдээлэл сургалт өгч хамтран ажиллаж байна. | 90 |
| 24. | Арга хэмжээ 4.1.4<br>*Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.10* | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 100 иргэнээс сэтгэл | Сэтгэл ханамжийн судалгаа авч, хэрэгжүүлсэн | ЭМДЕГ-аас жил бүр орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааг үнэлэх "Сэтгэл ханамжийн судалгаа"-нд гэрээт эрүүл мэндийн | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | - | | ханамжийн судалгаа авч нэгтгэсэн. | арга хэмжээний нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | байгууллагын 135 албан хаагч хамрагдсан.<br>Иргэдээс авах “Сэтгэл ханамжийн судалгаа”-ны 10 асуумжыг бэлтгэж QR код үүсгэн байгууллагын пэйж хуудас болон гэрээт эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа 230 иргэн судалгаанд хамрагдсан. | |
| 25. | Арга хэмжээ 4.1.5<br>*Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.15*<br>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | - | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 28 ирснийг 100 хувь шийдвэрлэсэн. | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Өргөдөл гомдлыг тухай бүр хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллаж байна.<br>Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улиралаар гарган хүргүүлсэн. Үүнд:<br>➢ Эрүүл мэндийн даатгалаа давхардуулан төлсөн өргөдөл 12<br>➢ Мэдээллээ шинэчлүүлэх овог нэр засварлах хүсэлт гаргасан 5<br>➢ Төр хариуцах иргэн 23 иргэний мэдээллийг health.gov.mn програмд оруулж мэдээг хүргүүлсэн.<br>Утсаар болон биеэр ирж үйлчилгээ авч байгаа иргэдэд асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэж, гарын авлага өгч хэлтсийн үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж байна. | 100 |
| 26. | Арга хэмжээ 4.1.6<br>Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан болон үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллана | - | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 17 удаа гаргаж хэрэгжилт 100 хувь | Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | Ерөнхий газрын даргын шуурхай хуралдаанд 14 удаа оролцсон. Хурлаас гарсан үүрэг даалгаварын 14 биелэлт, хугацаатай судалгаа 12-ийг цаг хугацаанд нь хүргүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийн хангаж тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн. | | | |
| 27. | Арга хэмжээ 4.1.7 Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, орон нутгаас зохион байгуулсан ажилд оролцож хэрэгжилтийг хангаж ажиллана | - | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг тухай бүр хүргүүлж, орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвхитэй хамрагдсан. | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвхитэй оролцсон байна. | ЭМДЕГ-аас хугацаатай судалгаа 3, санал асуумж 3, бусад судалгаа 4 ирснийг хугацаанд гаргаж хүргүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулахад үе шаттай өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд хэрэгжүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлигийн дагуу ЭМДХ-ийн хамт олон Эрүүл мэндийн газартай хамтран голын эхэнд 133 хайлаас модыг нөхөн тариалт, усалгаа хийж, хогийг түүсэн.<br>Байгууллагын ойр орчмын хогийг түүж цэвэрлэх, хэлтсийн өрөө тасалгааны их цэвэрлэгээг улирал тутамд хийж байна.<br>Бямба гариг бүрийн өглөө 07 цагт зохион байгуулагддаг бүх нийтийн гүйлтэд оролцож байна. | 100 |
| 28. | Арга хэмжээ 4.1.8 Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | - | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ГТ-ний биелэлтийн хувь | Хэлтсийн чанар, төлбөрийн хяналтын 2 мэргэжилтэнтэй гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | ЭМДЕГ-ийн дарга, аймгийн засаг даргатай “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” байгуулан биелэлтийг хагас жилээр тайлагнасан. Хэлтсийн 2 мэргэжилтэнтэй “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” байгуулж хагас жилээр биелэлтийг дүгнэсэн.<br>Долоо хоног бүрийн мэдээллийн цагийн дараа албан хаагчдад мэдээлэл өгч ажил үүргийг хувиарлаж, биелэлтийг хангуулан ажиллаж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр тайлагнаж дүгнэн ЭМДЕГ-т хүргүүлсэн. | | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/192 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг мөрдөн ажиллаж байна. Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтыг Able цахим программд бүртгүүлж, сар бүрийн 05, 20-ны өдрүүдэд цагийн бүртгэлийг Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлж байна.<br>Албан хаагчид ажлын цагийн хоцрогдолгүй, цаг ашиглалтын журмыг чанд сахиж, үйлчлүүлэгчээс гомдол чирэгдэлгүй, ёс зүйн зөрчил дутагдалгүй ажиллаж байна. | |
| 29. | Арга хэмжээ 4.1.9<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, заавшрын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Архивын нэгжийн тоо (боть) | 2024 оны 22 архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байна. | 2024 оны санхүүгийн баримт бичгийн 20 архивын нэгжийг архивын хуулийн дагуу стандартын дагуу архивласан. Аймгийн архивын шалгалтад орж заавар зөвлөгөө авсан.<br>Албан бичиг хөтлөлтийн мэдээг улирлаар хүргүүлсэн.<br>Үүнд:<br>➢ Явсан албан тоот-65<br>➢ Ирсэн албан тоот-30<br>➢ Явсан дотоод албан бичиг-8<br>➢ Ирсэн дотоод албан бичиг-27 | 100 |
| 30. | Арга хэмжээ 4.1.10<br>Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна. | - | -Хэрэгжилтийн хувь<br>-Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо, | - | Албан хэргийг хос бичгээр хэрэгжүүлэн ажилласан байна. | Байгууллага хооронд явуулж байгаа албан бичгийг хос бичгээр хөтлөн гаргаж байна. Нийт хос бичгээр 60 албан бичгийг хөтлөн гаргасан.<br>Хэлтсийн пэйж хуудаст оруулж байгаа зурагт хуудас, мэдээлэлд байгууллагын нэрийг Монгол бичгээр байршуулан оруулж байна. | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 31. | Арга хэмжээ 4.1.11<br>Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ. | - | Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо | - | Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна. | Хэлтсээс явж байгаа албан бичгийг хэлтсийн дарга тоон гарын үсгээр гарган цахимаар баталгаажуулан илгээж байна. | 90 |
| 32. | Арга хэмжээ 4.1.12<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана | - | Хэрэгжилтийн хувь | - | ЭМДЕГ-аас гаргасан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Авилгалын эсрэг сургалтанд хамрагдаж, ЭМДЕГ-ийн даргатай авилга ашиг сонирхолын зөрчилгүй ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэгээ цаг хугацаанд нь мэдүүлсэн. | 100 |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Эрүүл мэндийн даатгалын шинэчлэгдсэн тогтоол шийдвэрүүдийг тухай бүр нь судалж, танилцан бүрэн мэдлэгтэй болно. | Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх сургалт, семинарт хамрагдана. | Тогтоолын шинэчлэлтэй холбоотой 6 сургалтад хамрагдсан | Сургалтад бүрэн хамрагдсан байна. | Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хувь хэмжээг тогтоох тухай МУЗГ-ын 02 тоот тогтоол, МУ-ын Эрүүл мэндийн сайдын А/04 тоот “Эрт илрүүлэг үзлэг оношилгоо” тушаал, ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, 04 дүгээр шинэчлэгдсэн тогтоол, ЭМДЕГ-н даргын А/12 тоот “Хамралтын төлөвлөгөө батлах” тушаал, ЭМДЕГ- ийн А/45 тоот “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд олгох санхүүжилтийн 2025 оны төсвийн хуваарийг батлах тухай” тушаал, ЭМДЕГ-ийн даргын А/30 тоот | 2025.01.02<br>-<br>2022.12.31 | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Нэхэмжлэлийг хянах журам", МУЗГ-ын 214 тоот "Албан хэрэг хөтлөлтийн журам, ЭМДЕГ-ийн дарга, НДЕГ-ийн дарга нарын хамтран ажиллах гэрээтэй танилцаж албан ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 2. | Арга хэмжээ 2. *Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4* ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад бүрэн хамрагдсан | ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад хамрагдаж мэдлэг, мэдээлэл авсан байна. | ЭМДЕГазраас зохион байгуулсан ЭМДҮЗ-ийн шинэчилсэн тогтоолын сургалт, бусад сургалт хэлэлцүүлэгт 14 удаа хамрагдсан.<br>Лхагва гариг бүрийн мэдээллийн цагт 8 удаа цахимаар хамрагдсан. | 2025.01.02<br>-<br>2022.12.31 | 100 |
| 3. | Арга хэмжээ 3. Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ. | Хамрагдсан сургалтын тоо | Нийт 30 удаагийн сургалтад оролцсон. | Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна. | Аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан "Төрийн албаны шинэчлэл, үе шат сургамж" уулзалт, Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалтад тус тус хамрагдсан.<br>Төрийн албаны төв зөвлөлөөс зохион байгуулсан пүрэв гаригийн цахим сургалтанд долоо хоног бүр хамрагдаж байна. | 2025.01.02<br>-<br>2022.12.31 | 100 |
| 4. | Арга хэмжээ 4. Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан. | Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн | Төрийн албан хэргийг 2025 оноос кирилл болон монгол бичгээр хослуулан хөтлөхтэй холбогдуулан албан тоотыг хос бичгээр хослуулан бичиж байна.<br>Монгол бичгийн цахим сургалтад 2023, 2024 онд хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэн сертификат авсан. | 2025.01.02<br>-<br>2025.12.31 | 85 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэглээний орчин сайжирсан байна. | Мөн хэлтсийн пэйж хуудсанд оруулж байгаа мэдээлэлд байгууллагын нэрийг монгол бичгээр бичиж оруулсан. | | |
| | Төлөвлөгөөний биелэлт | | | | | | 93.4 |

***Төлөвлөгөөг үнэлсэн:*** ***Төсвийн шууд захирагч***

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ........................ С.ЭНХБОЛД

........................

***Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:*** ***Нэгжийн дарга***

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА ........................ Б.ОЮУНЦЭЦЭГ

2025.06.24 ........................

УЖА0067
6263305

***Тайлагнасан:*** ***Нэгжийн дарга***

СҮХБААТАР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА ........................ Ч.ТАМИРАА

........................

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
СҮХБААТАР АЙМАГ